

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023. 12. 27

#### Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

#### Нэгжийн нэр:

Алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллага

#### Албан тушаалын нэр:

Зохицуулагч

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-8

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Олимпын  
гудамж, өөрийн байр.

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хотой

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц  
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад  
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй  
байдал үүссэн, террорист халдлага, онц  
болон дайны байдал зарласан, онц ноцтой  
гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй  
тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд  
ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын  
тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн  
хэрэгжилтийг хангуулах, замын хөдөлгөөнд хяналт тавих, хөдөлгөөн зохицуулах,  
хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн хариуцах, энэ чиглэлээр цагдаагийн төрөл,  
мэргэжлийн бусад нэгж, алба хаагчтай харилцан ажиллах.

#### Албан тушаалын зорилт:

- 1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд биечлэн хариуцах, хуулиар харьяалуулсан зөрчил шалган шийдвэрлэх
- 2.Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга зүй, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох санал танилцуулах
- 3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийц бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

[illegible]

|                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                  |   |
|---------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------|---|
|                           | <p>1.7.Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хангаж, үр дүнг тооцон танилцуулах,</p> <p>1.8.Хариуцсан нутаг дэвсгэр /бүс/-ийн хэмжээнд хөтлөгдвөл зохих бүртгэл, судалгааны баяжилтыг хариуцах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах,</p> <p>1.9.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, хуулиар харьяалуулсан зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах:</p>                                                                                                                                                                                           |                                                                  | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <p>2.1.Замын хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих, хамгаалалтын чиг үүргийн бодлого, стратеги, арга зүй, үйл ажиллагааны стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, боловсронгуй болгох чиглэлээр чиг үүргийн хүрээнд холбогдох санал танилцуулах</p> <p>2.2.Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх, дүрэм журмыг сахиулах, гомдол, мэдээллийг хүлээн авах, зөрчил шалгаж шийдвэрлэх, үйл ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, боловсронгуй болгох ажилд оролцох, чиг үүргийн хүрээнд холбогдох санал танилцуулах,</p> <p>2.3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих, хөдөлгөөн зохицуулах, хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр гадаад орнуудын туршлагыг судлах, танилцуулах,</p> | Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл боломж сайжирсан байна. | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <p>3.1.Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, харьяа нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан хууль тогтоомж, захирамж, тогтоол, тушаал шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах:</p> <p>3.2.Замын хөдөлгөөний хяналт, зохицуулалт, хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруул, дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, бусад байгууллагыг</p>                                                                                                                                                  | Хэлтсийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна.      | Г |

|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |  |   |
|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|---|
|  | мэдээллээр хангах,<br>3.3.Хууль тогтоомж дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, шууд удирдах даргаас хариуцуулсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах,<br>3.4.Байгууллагын дотоод журмыг мөрдөж, өөрийн болон алба хаагч, байгууллагын аюулгүй байдлыг хангах, өмч, эд хөрөнгө, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, зарцуулалт, ашиглалтын журмыг мөрдөх,<br>3.5.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдүүлэх, явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах,<br>3.6.Авлигын сэжигтэй тохиолдол бүрийг холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдээлнэ, |  | Г |
|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |  | Г |
|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |  | Г |
|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |  | Г |

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

|                  |                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Боловсрол</b> | Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Мэргэжил</b>  | Эрх зүйч /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, Авто инженерчлэл /071601/, Авто машин ашиглалт, авто аж ахуй (071602), Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл (071604) |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Мэргэшил</b>  | Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Туршлага</b>  | Цагдаагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх.                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Ур чадвар</b> | Дүн шинжилгээ хийх                                                                                                                                                                                          | -Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх,<br>-Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах,<br>-Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй;                                                                                                                                                                                   |
|                  | Асуудал шийдвэрлэх                                                                                                                                                                                          | -Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, тайлагнах, хариуцах;<br>-Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг тайлагнах,                                                                                                                                                                                                |
|                  | Багаар ажиллах                                                                                                                                                                                              | -Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>-Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>-Багаар зохион байгуулан удирдан ажиллах;                                                                                                                 |
|                  | Бусад                                                                                                                                                                                                       | -Ажил гүйцэтгэх хэрэгжүүлэх.<br>-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, Монгол хэл бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх.<br>-Компьютерын Microsoft office програмууд болон дотоод сүлжээнд бүрэн ажиллах чадвартай байх;<br>-Оффисын төхөөрөмжүүд дээр ажиллах чадвартай байх;<br>-Зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар. |

#### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

##### Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Нийслэлийн замын хөдөлгөөний хяналын хэлтсийн дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:  
Батлагдсан орон тоо.

##### Бусад харилцах субъект:

##### Шууд харилцах байгууллага:

Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

##### Шууд бус харилцах байгууллага:

Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн;

/Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална./

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:.....

Шийдвэрийн огноо:.....

Дугаар:.....

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр.

Дугаар: 9/401

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Танилцсан:

Албан тушаалтан:.....

.....

2023 оны .... дугаар сарын ....